



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/07

Арвайхээр сум

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 23/14 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг хавсралтад тусгагдсан холбогдох сумдын Засаг дарга нарт шилжүүлсүгэй.

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүн, хэрэгжилтийг тайлагнахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

8224 11 0015

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 007 дугаар захирамжийн хавсралт

Сумын Засаг дарга нарт худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт

№	Тогтоолын хавралтад тусгагдсан дугаар	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Тогтоолын хоёрдугаар хавсралтад батлагдсан аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтын 15-т тусгагдсан	Есөнзүйл сумын хөдөлмөр зуслан	30,000.0
2	Тогтоолын гуравдугаар хавсралтад батлагдсан аймгийн автозамын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтын 2-т тусгагдсан	Хархорин сумын автозамын засвар, арчлалтын зардал	30,000.0
3	Тогтоолын гуравдугаар хавсралтад батлагдсан аймгийн автозамын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтын 4-т тусгагдсан	Уянга сумын автозамын нөхөөс	15,000.0
4	Тогтоолын гуравдугаар хавсралтад батлагдсан аймгийн автозамын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтын 4-т тусгагдсан	Хужирт сумын автозамын нөхөөс	15,000.0
5	Тогтоолын тавдугаар хавсралтад батлагдсан аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хийгдэх их засвар, төсөл арга хэмжээний жагсаалтын боловсролыг салбарын 13-т тусгагдсан	Гучин-Ус сумын цэцэрлэгт хүнсний агуулах барих	27,000.0
6	Тогтоолын тавдугаар хавсралтад батлагдсан аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хийгдэх их засвар, төсөл арга хэмжээний жагсаалтын соёлын салбарын 3-т тусгагдсан	Гучин-Ус сумын төвийн засвар	10,000.0
7	Тогтоолын тавдугаар хавсралтад батлагдсан аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хийгдэх их засвар, төсөл арга хэмжээний жагсаалтын эрүүл мэндийн салбарын 3-т тусгагдсан	Баянгол сумын эмчийн байрны засвар	20,000.0
		Нийт дүн	147,000.0